

Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төслийг даган боловсруулсан бусад хуулийн төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн саналын товъёог

1	Монголбанк 2021.04.30 А-1/444	Иргэний нийгмийг хөгжүүлэх, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах аливаа шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Холбооны эрх зүйн байдлын хуулийн төслийн үзэл баримтлал, холбооны хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны чиглэл, ил тод байдал, бүртгэл хяналтын үр ашигтай тогтолцоо бүрдэж, төрийн зүгээс иргэний нийгэм, ашгийн бус салбар, түүний үр нөлөөний талаар баримтлах үр дүнтэй бодлоготой байх боломж бүрдэх тул Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тус тус дэмжиж байгааг үүгээр илэрхийлье. Монгол Улс Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүн улсын хувьд Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (цаашид "ФАТФ" гэх)-аас гаргасан 40 Зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хууль тогтоомждоо тусган ажиллах үүргийг олон улсын өмнө хүлээдэг. Тодруулбал, ФАТФ-ын Зөвлөмж 8-д “Улс орнуудын олон төрлийн хууль эрх зүйн хэлбэрийг харгалзан ашгийн бус байгууллага (цаашид "АББ" гэх)-ыг ФАТФ-аас үйл ажиллагааны хэлбэрээр нь тодорхойлолтыг батлав. Энэ тодорхойлолт нь энгийн ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа үндэслэлээр бус харин терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байгууллагын үйл ажиллагаа, шинж чанарт үндэслэсэн болно. Энэ зөвлөмжийн зорилгын үүднээс АББ гэж буяны, шашны, соёлын, боловсролын, нийгмийн, нийгэмлэгийн зорилгоор эсвэл бусад төрлийн "сайн үйлс" -ийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор хөрөнгө босгох, зарцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, гэрээ хэлцэл болон байгууллагыг хэлнэ.” гэж заасан.	Зарчмын хувьд дэмжсэн. 1.1.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн удирдлагын менежментийг үр дүнтэй, хариуцлага хяналттай байх хүрээнд төлөөллийн удирдлага, гүйцэтгэх удирдлага, хяналтын механизмыг бүрдүүлэх ерөнхий зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан бөгөөд хуульд зааснаас бусад зохицуулалтыг өөрийн дүрмээр зохицуулахаар төсөлд тусгасан. Түүнчлэн бүртгэл, тайлагналтын ил тод механизмыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн бөгөөд үүнтэй уялдаад хариуцлагыг нэмэгдүүлсэн болно. Саналыг тусгаагүй. 1.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг соён гэгээрүүлэх чиглэлээр Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д ашгийн төлөө бус хуулийн этгээдийн чадавхыг дэмжих, дотоод засаглал, ёс зүйн жишгийг тогтоож хөгжүүлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг авах, 39.1.4-т бүртгэлийн болон статистикийн байгууллагуудтай хамтран ашгийн төлөө бус хуулийн этгээдийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийхээр, 39.1.5-д ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нийтэд тустай үйл ажиллагааны болон сайн дурын тайлан авах, үйл ажиллагааны үр нөлөөг нэгтгэн дүгнэх,
---	---	---	--

	Иймээс Зөвлөмж 8-д заасан тодорхойлолтод хамаарах ашгийн бус байгууллага, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн үйл ажиллагааг дотоодын хууль тогтоомжоор зохицуулахдаа ФАТФ-ын Зөвлөмж 8, үүнтэй холбогдох бусад зөвлөмжид заасан стандартыг тусгах үүргийг Монгол Улс хүлээсэн. Холбооны эрх зүйн байдлын тухай болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийн зохицуулалтаас харахад Холбоо болон Сангийн эрхлэх үйл ажиллагаа нь ФАТФ-ын Зөвлөмж 8-д заасан шинжид хамаарахаар байна. Иймд дээрх хуулийн төслүүдэд ФАТФ-ын Зөвлөмж 8-д заасан дараах асуудлыг тусгах, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь оновчтой байна: 1.Терроризмыг санхүүжүүлэх, түүний эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийх шаардлагатай бөгөөд энэ хүрээнд улс орнууд дараах арга хэмжээг авах талаар зохицуулах нь зүйтэй: 1.1.АББ-ын удирдлага, менежмент нь хариуцлагатай, бүртгэлтэй байх, шударга байхыг дэмжиж, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх тодорхой бодлоготой байх; 1.2.АББ болон хандивлагчдын нийгэмлэгийн АББ-ын терроризмыг санхүүжүүлэхэд өртөх аюул, заналхийлэл болон АББ-ын энэ аюулаас сэргийлэх талаар авах арга хэмжээний мэдлэгийг дээшлүүлэх, гүнзгийрүүлэх, боловсролын хөтөлбөрийг дэмжиж, хэрэгжүүлэх; 1.3.Терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, аюул заналхийллийг арилгах шилдэг туршлагыг боловсруулж боловсронгуй болгох, улмаар терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдахаас хамгаалахын тулд АББ-уудтай улс орнууд хамтран ажиллах; 1.4.Аливаа бүс нутаг, улс орны санхүүгийн салбарын чадавх, буяны болон хүмүүнлэгийн асуудлын хойшлуулшгүй байдал зэргийг харгалзан АББ-ыг зохицуулалттай санхүүгийн салбараар /тухайлбал, энэ төрлийн мэдээллийг татварын байгууллага, СМА, донор байгууллага, хууль сахиулах болон тагнуулын байгууллагаас авч болно/ гүйлгээ хийхийг дэмжих.	зөвлөмж гаргахаар, 39.1.8-д ашгийн төлөө бус хуулийн этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх магадлал, эмзэг байдлын талаарх судалгааг хийх болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.1.8-д заасан үндэсний эрсдэлийн үнэлгээг 2 жил тутамд хийх, эрсдэлийг хянах, бууруулахад эрх бүхий байгууллагад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг Иргэний нийгмийг дэмжих зөвлөл хэрэгжүүлэхээр заасан болно. Түүнчлэн хуулийн төсөлд Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг соён гэгээрүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж болохоор заасан болно. Саналыг тусгаагүй. 1.4.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүгийн хариуцлагыг сайжруулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ФАТФ-ын зөвлөмжийн хүрээнд Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д холбооны зохицуулалтгүй санхүүгийн сувгаар мөнгөн гүйлгээ хийхийг хориглосон бөгөөд энэхүү хориглолттой холбогдуулан Зөрчлийн тухай хуульд хариуцлагыг оруулж өгсөн болно. Саналыг тусгаагүй. 2.1.Холбоо нь хуулийн этгээд болохын хувьд Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэлтэй байна. Түүнчлэн Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 39 дүгээр зүйлийн 39.1.7-д Иргэний нийгмийг дэмжих зөвлөл нь ашгийн төлөө бус
--	--	---

	2.АББ-ын эрсдэлд суурилсан зорилтот хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар зохицуулах шаардлагатай. Энэ хүрээнд үр дүнтэй хяналт, шалгалтыг дэмжих алхмуудыг хийх шаардлагатай. Терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдах эрсдэлтэй АББ-уудад бодит байдал дээр эрсдэлд суурилсан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авах, эдгээрийг хийх эрх бүхий этгээд, түүний эрх хэмжээ, АББ, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж буй хүнд гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага /данс царцаах, траст төлөөлөгчийг болиулах, торгох, сертификатыг хүчингүй болгох, лицензийг хураах, бүртгэлээс хасах зэрэг хариуцлагын төрлийг тусгах/-ын тогтолцоо зэргийг хуульчлах шаардлагатай: 2.1.АББ нь тусгай зөвшөөрөлтэй, эсхүл бүртгэлтэй байх. Энэ мэдээллийг эрх бүхий байгууллагад болон олон нийтэд нээлттэй байлгах; 2.2.АББ-аас өөрсдийн үйл ажиллагааны зорилго, зорилт, удирдах ажилтан, удирдах зөвлөлийн гишүүд гэх мэт өмчилж, хянаж, үйл ажиллагааг нь чиглүүлж буй хувь хүмүүс болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг хадгалж байхыг шаардах. Энэ мэдээллийг АББ-аас өөрөөс нь, эсхүл холбогдох эрх бүхий байгууллагаас авах боломжтой байх; 2.3.АББ нь орлого, зарлагыг дэлгэрэнгүй байдлаар харуулах жилийн санхүүгийн тайлан гаргаж байх; 2.4.ААБ-Д бүх хөрөнгө нь бүртгэлтэй байх, зарцуулалтыг нь тодорхойлсон үйл ажиллагааных нь зорилго, зорилтод нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж байх шаардлагыг тавих; 2.5.АББ-аас үр шим хүртэгчид /буяны, хүмүүнлэгийн эсхүл бусад төрлийн тусламж авдаг хувь хүн эсхүл бүлэг хувь хүн/, эцсийн өмчлөгч, эсхүл хамаарал бүхий этгээдийн хэн болох, эрх үүрэг болон эерэг байдлыг тодорхойлсон арга хэмжээ авах, баталгаажуулах, мөн тэдгээр нь террористууд, террорист байгууллагыг дэмжих зорилгоор ААБ-тай холбоогүй, эсхүл ашигладаггүй гэдгийг баталгаажуулах холбогдох шаардлага хангасан арга хэмжээ авахыг шаардах. Мөн буяны санг	хуулийн этгээдийн мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, олон нийтэд нээлттэй мэдээлэх чиг үүргийг заасан. Түүнчлэн уг институт нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийх, нийтэд ил тод мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд заасан болно. Саналыг тусгаагүй. 2.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдээс өөрсдийн үйл ажиллагааны зорилго, зорилт, удирдах ажилтан, удирдах зөвлөлийн гишүүд гэх мэт өмчилж, хянаж, үйл ажиллагааг нь чиглүүлж буй хувь хүмүүс болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт болон Иргэний нийгмийг дэмжих зөвлөлийн мэдээллийн санд нээлттэй хадгалагдаж, мэдээлэгдэнэ. Саналыг тусгаагүй. 2.3.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 13 дугаар зүйлд холбоо нь орлого, зарлагын мэдээллийг агуулсан санхүүгийн, үйл ажиллагааны тайланг гаргаж холбогдох байгууллагад гаргаж байх зохицуулалтыг нарийвчлан тусгасан бөгөөд Зөрчлийн хуульд уялдуулан хариуцлагыг оруулсан. Саналыг тусгаагүй. 2.4, 2.5.Холбооны санхүүгийн тайланд, үйл ажиллагааны тайланд энэ талаар дурдсан байх бөгөөд 1 сая төгрөгөөс дээш төгрөгийн хандив өгсөн хандивлагчийг бүртгэж байх, тайланд энэ талаар тусгах талаар хуулийн төсөлд тусгасан.
--	--	--

		террористууд, террорист байгууллагыг санхүүжүүлэх, дэмжих зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх хүрээнд АББ-уудаас хандивлагчийг нууцлах үүргээ биелүүлэхийн хажуугаар чухал, том хандивлагчийн мэдээллийг баримтжуулах зохистой арга хэмжээ авахыг шаардах; 2.6.АББ-аас тухайн байгууллагын зорилго, зорилтын дагуу мөнгө хүлээн авсан, зарцуулсан эсэхийг нягтлахын тулд дотоод, гадаад гүйлгээний нарийвчилсан бүртгэлийг дор хаяж таван жилийн хугацаанд хадгалах, шаардлагатай бол түүнийг эрх бүхий байгууллагад хэрэгцээтэй үед гаргаж өгөхийг шаардах. Шаардлагатай тохиолдолд АББ-ын буяны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгох боломжтой байх. 3.Үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах, мэдээлэл цуглуулах арга хэмжээний хүрээнд дараах асуудлыг зохицуулах шаардлагатай: 3.1.АББ-уудын талаар холбогдох мэдээллийг хадгалдаг бүх шатны эрх бүхий байгууллагуудын хооронд үр дүнтэй хамтын ажиллагаа, уялдаа холбоо болон мэдээлэл солилцоог хангах; 3.2.Террорист үйл ажиллагаа эсвэл террорист байгууллагад урвуулан ашиглагдаж эсвэл тэдгээрийг идэвхтэй дэмжиж байгаа гэж сэжиглэгдэж байгаа АББ-ыг мөрдөн шалгах чадвартай, нарийн мэргэшсэн мөрдөгчидтэй байх, байнгын мэргэшүүлэх тогтолцоотой байх; 3.3.Мөрдөн шалгах явцад тодорхой АББ-ын удирдлага, менежментийн талаарх мэдээлэл (санхүүгийн болон төлөвлөгөөний мэдээлэл гэх мэт) олж авах бүрэн эрхтэй байх; 3.4.АББ-ыг: (1) террорист байгууллагуудтай холбоотой, эсхүл хөрөнгө цуглуулах үйл ажиллагаанд нь халхавч болж байгаа; (2) хөрөнгө царцаах арга хэмжээнээс зайлсхийх, эсхүл терроризмыг бусад аргаар дэмжих зэрэг терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдах эрсдэлтэй; (3) хууль ёсны үйл ажиллагаанд зарцуулагдах байсан хөрөнгийг террористууд, террорист байгууллагуудад шилжүүлсэн гэж сэжиглэх үндэслэлтэй тохиолдолд урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулахын тулд шаардлагатай мэдээллийг эрх	Түүнчлэн Иргэний нийгмийг дэмжих зөвлөлөөс 2 жилд тутамд хийгдэх ашгийн төлөө бус хуулийн этгээдийн салбарын терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг хийхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж байх чиг үүргийг хуулиар олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Саналыг тусгаагүй. 3.1.Хуулийн төсөлд Иргэний нийгмийг дэмжих зөвлөл нь холбоо, сангийн тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийж, нийтэд ил тод мэдээлэх, сурталчлахаас гадна тэдгээрийн мэдээллийн санг үүсгэх, хөтлөх арга хэмжээг явуулах зохицуулалтыг тусгасан. Энэ бүртгэл мэдээллийг Улсын бүртгэлийн байгууллага, статистикийн байгууллагатай хамтран явуулах, мэдээлэл солилцохоор зохицуулсан болно. 3.2.Хуулийн төсөлд хамаарахгүй санал бөгөөд холбогдох хууль сахиулах байгууллагын асуудал болно. 3.3. Хуулийн төсөлд хамаарахгүй санал бөгөөд холбогдох хууль сахиулах байгууллагын асуудал болно. 3.4.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.10-д Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 14.2-т заасан үйл ажиллагаа болон тэдгээр этгээдтэй харилцаа холбоо тогтоох, санхүүжилт авах зэрэг үйл ажиллагааг явуулахыг хориглохоор заасан. Түүнчлэн дээрх хуулийн төслийн 14.3-т Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах,
--	--	--	--

	бүхий байгууллагатай цаг алдалгүйгээр солилцох механизмтай байх. 4.АББ-ын талаарх мэдээлэл авах олон улсын хүсэлтэд хариу өгөх чадамжтай байх зохицуулалтыг хуульд тусгах. Олон улсын хамтын ажиллагааны Зөвлөмжийн заалтад нийцүүлэн терроризмыг санхүүжүүлэх, терроризмыг дэмжиж байгаад сэжиглэгдсэн тодорхой АББ-ын талаар мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх байгууллага болон зохицуулах журмыг тодорхойлох тусгах. 5.Түүнчлэн ФАТФ-ын Зөвлөмж 8-д заасны дагуу "Төр, хувийн хэвшлийн болон АББ-уудын хооронд хамтын ажиллагааны харилцаа холбоог хөгжүүлэх нь АББ-ын эрсдэлийг ойлгох, эрсдэлийг бууруулах стратеги, мэдлэгийг дээшлүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, АББ-уудын терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг тул терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд эрдэм шинжилгээний судалгааг хөгжүүлэх, АББ-уудад мэдээлэл солилцон, дэмжиж ажиллах"-ыг улс орнуудаас шаарддаг. Иймээс энэ талаар тодорхой зохицуулалтыг хуульчлах." Нөгөөтээгүүр, ФАТФ-аас 40 Зөвлөмжид заасан стандарт шаардлагыг мөрдөж ажиллахыг улс орнуудаас шаарддаг бөгөөд энэхүү шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй, стратегийн дутагдалтай, хамтран ажиллахгүй улс орон гэх ангилалд орох эрсдэл үүсдэгийг харгалзан ашгийн бус байгууллага, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг зохицуулж байгаа аливаа хуулийн төсөлд дээрх саналыг тусгах талаар арга хэмжээ авах шаардлагатай байна. Мөн Валютын зохицуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-т "Валют гэж Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хэлнэ" гэж тодорхойлсон байдаг. Валют гэдэг ойлголтод Монгол Улсын үндэсний валют агуулагдаж байх тул Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дах хэсгийн "... валют болон үндэсний мөнгөн	мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглохоор заасан болно. Дээрх байгууллага, хувь хүмүүсийн жагсаалтыг цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх байгууллагаас гаргаж нийтэд мэдээлэхээр төсөлд тусгасан. Саналыг тусгаагүй. 4.Хуулийн төсөлд тусгайлан тусгах шаардлагагүй. Өөрөөр хэлбэл терроризмыг дэмжиж байгаа, эсхүл сэжиглэгдэж ашгийн төлөө бус хуулийн этгээдийн талаар мэдээллийг холбогдох хуулийн дагуу гадаад улсын хамтын ажиллагааны хүрээнд өгөх боломжтой. 5.Саналыг тусгасан.
--	--	---

		тэмдэгтийн...” гэснийг “валютын ” гэж , мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.13 дах заалтын “Хэрэглэгчдийн” гэснийг “хэрэглэгчийн” гэж өөрчлөх саналтай байгааг хүлээн авч хуулийн төсөлд тусгаж өгөхийг Танаас хүсье.	
2	Хүний эрхийн үндэсний комисс 2021.04.27 1/472	Холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өгөх санал: 1.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-дэх хэсэгт заасан Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь өөрийн дүрэмд заасан үйл ажиллагааны зорилго, чиглэлтэй уялдуулан нийтэд тустай үйл ажиллагааг төлбөртэй болон төлбөргүйгээр эрхлэхээр заасан нь үндсэн үзэл баримтлалтайгаа нийцэх эсэхийг тодруулах; 2.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд холбооны эрхлэн явуулах нийт үйл ажиллагааны 20 хувиас хэтрүүлэхгүй аж ахуй эрхэлж болно” энэ заалтыг хэрэгжүүлэхийн тулд татварын тайланг 2-3 жилдээ нэг удаа тайлагнах зохицуулалт нэмэх; 3.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1.8-д заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх магадлал, эмзэг байдлын талаарх судалгааг хийх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.1.8-д заасан үндэсний эрсдэлийн үнэлгээг 2 жил тутамд хийх, эрсдэлийг хянах, бууруулах гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулах эрх бүхий байгууллагад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн үнэлгээгээр эрсдэлтэй гэж гарвал ямар эрх зүйн үр дагавар үүсэхийг хуулийн төсөлд тодорхой заах; 4.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 40.1-д заасан дансанд зориулж улсын болон орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж болно” гэж заасныг тодорхой болгож хувь хэмжээг зааж өгвөл үйл ажиллагаа явуулах санхүүгийн баталгааг хангах тул анхаарах;	Нэг.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл: 1.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1-д нийтэд тустай үйл ажиллагааг төлбөртэй болон төлбөргүй гүйцэтгэхээр заасан бөгөөд нийтэд тустай үйл ажиллагааг төлбөртэй гүйцэтгэсний орлогыг зөвхөн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төсөлд тусгасан. Энэ нь гишүүддээ ашиг хуваарилсан ашгийн төлөө үйл ажиллагаа болохгүй. Саналыг тусгаагүй. 2.Татварын тайланг татварын хууль тогтоомжийн дагуу улирал, жилээр тайлагнахаар заасан болно. Саналыг тусгаагүй. 3.Холбоо нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гарсан тохиолдолд тухайн эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлийг бууруулах арга хэмжээг авах нь зүйтэй байдаг. Тухайлбал, үнэлгээгээр хууль эрх зүйн орчин сул байх, тайлагналт хангалтгүй байгаа талаар үнэлэгдсэн бол тухайн хангалтгүй үнэлэгдсэн шалтгаан, эрсдэлийг үүсгэгч нөхцөлийг арилгах арга хэмжээг авна. Хуулийн төсөлд тусгайлан заах боломжгүй бөгөөд харин эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, уг төлөвлөгөөний дагуу арга хэмжээг авдаг. Тухайлбал, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, соён

			гэгээрүүлэх арга хэмжээг авах зэрэг болно. Саналыг тусгаагүй.
			4.Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтийн хувь хэмжээг хуульд тусгайлан заахад хүндрэлтэй. Саналыг тусгаагүй.
3	Санхүүгийн зохицуулах хороо 2021.04.09 1/1351	Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд өгөх санал: 1.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Холбоо нь дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд холбооны эрхлэн явуулах нийт үйл ажиллагааны 20 хувиас хэтрүүлэхгүй аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болно гэж заасан бөгөөд уг зохицуулалтын “нийт үйл ажиллагаа” гэдгийг хэрхэн тодорхойлох талаар тодорхой заагаагүй байх тул нийт орлогын 20% эсвэл нийт хөрөнгийн 20% гэх мэт тодорхой зохицуулалт тусгах; 2.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд “тус холбоог үүсгэн байгуулсан гишүүд нь сүүлд шинээр нэгдсэн гишүүдээс давуу эрх эдлэхийг хориглоно” гэсэн заалт нэмэх; 3.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан “Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл” гэснийг нэр томьёо хэсэгт тайлбарлах; 4.Хуулийн төслийн 17 дугаар зүйлд 17.1-д “гишүүдээс хураамж татах тохиолдолд хураамжийн хэмжээг тогтоох” гэж нэмэх; 5. Хуулийн төслийн 22 дугаар зүйлд заасан бүх гишүүдийн хурлыг цахимаар хийхтэй холбогдуулан цахим хуралдааны дэгтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгах зэрэг болно.	Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл: 1.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3-т 50 хувийг хэрхэн тогтоохыг журмаар нарийвчлан зохицуулах бөгөөд уг журмыг батлах субъектыг тусгасан болно. Саналыг тусгаагүй. 2.Хуулийн төсөлд агуулгын хувьд дээрх санал нь тусгагдсан байгаа болно. Саналыг тусгаагүй. 3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-т заасны дагуу “Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл” гэснийг нэр томьёоны тайлбар хийх шаардлагагүй байна. Саналыг тусгаагүй. 4.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1.12-т гишүүний хураамжийн хэмжээг холбооны дүрэмд заах тул саналыг тусгах шаардлагагүй болно. 5.Цахимаар хурлыг хийхтэй холбоотой дэг, журмыг холбоо өөрийн дүрмээр зохицуулах нь зүйтэй болно. Харин хуульд хурлыг цахимаар хийж болохыг нээлттэй зохицуулалтыг тусгасан болно. Саналыг тусгаагүй.
4	Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим	1.Холбооны тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт Улаан загалмайн нийгэмлэг, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Үйлдвэрчний эвлэл зэрэг бие даасан хуультай, олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааг тухайн хуулиар зохицуулснаас	1.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгайлсан хуулиар зохицуулж байгаа харилцааг тухайн хуулиар зохицуулах бөгөөд харин

	2021.04.08 1/206	бусад нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулахаар төсөлд тусгасан нь хэрэгжихэд маш хүндрэлтэй гэж үзэж байна. Учир нь эдгээр байгууллагууд нь хуулиар зохицуулаагүй олон харилцааг тухайн хуулийн үзэл баримтлал, өөрийн үйл ажиллагааны онцлог, урт хугацааны практикаас бий болсон тогтолцоо буюу “эко системд” нийцүүлж, дүрмээрээ нарийвчлан зохицуулдаг ба энэ хуулиар нийтлэг харилцааг зохицуулснаар дээр дурдсан “эко систем” алдагдах, үйл ажиллагааны бүтээмж, менежментийн үр дүнтэй, оновчтой байдал сулрах, үргүй зардал шаардагдах зэрэг хүндрэлүүд бий болохоор байна. Иймд бие даасан хуультай, тухайн хуулиараа зохицуулагддаг олон нийтийн байгууллагуудад Холбоо, Сангийн хууль хамаарахгүй байхаар заах нь зүйтэй. 2.Холбооны хуулийн олон зүйл заалтууд нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй”, мөн энэхүү хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангах, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих харилцааг зохицуулахад оршино” гэсэнтэй нийцэхгүй харагдаж байна. Тухайлбал, холбоодын үйл ажиллагаа, санхүүжилтийн бүтцийг тодорхойлох аргачлалыг Сангийн яам батлах, онцлог бүхий холбоодын үйл ажиллагааны зөвшөөрөл нь төрөөс бүрэн хамааралтай байх, холбоодын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хянах Нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн гишүүдийг Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, Ерөнхий сайд батлах зэргээр төрөөс хэт хамааралтай эрх зүйн орчин бүрдэхээр байна. Энэ нь нэг талаас Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.10 дахь хэсэгт заасан иргэдийн үндсэн эрх үл хангагдах, нөгөө талаас Засгийн газар, Сангийн яамны түвшинд аргачлал батлах, зөвшөөрөл олгох журам батлах, томилох-батламжлах шийдвэр гаргаж буй нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн цаашдын хөгжил, үйл ажиллагааны тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлнэ гэж ойлгож байна. Иймд Холбооны хуулийн төсөлд иргэдийн сайн дураар, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, төрөөс хараат бус байх зарчмыг хангах, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг төрийн чиг үүргийг	тусгайлсан хуулиар зохицуулаагүй нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулахаар заасан. Түүнчлэн зарим холбооны дотоод засаглалтай холбоотой асуудлыг өөрсдийн дүрмээр зохицуулахаар нээлттэй үлдээсэн болно. Санал нь хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй байна. Саналыг тусгаагүй. 2. Холбоо нь хуулийн этгээд болохын хувьд хууль тогтоомжид заасан шаардлагыг хангах, эрх үүргийг хэрэгжүүлэх ёстой байдаг. Түүнчлэн холбоо нь нийгмийн сайн сайхны төлөө болон гишүүдийн эрх ашгийг хамгаалах, ашгийн бус үйл ажиллагааг явуулах, гишүүддээ ашиг хуваарилахгүй байх зарчимтай. Гэхдээ холбоонд санхүүгийн тогтвортой байдлыг бий болгох хүрээнд аж ахуйн үйл ажиллагааг дүрэмдээ заасны дагуу явуулах, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого нь тухайн холбооны үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх, үндсэн үйл ажиллагааны 50 хувиас аж ахуйн үйл ажиллагаа нь хэтрэхгүй байх зарчмыг баримталсан болно. Харин 50 хувийг тогтоох аргачлалыг санхүү, татварын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тогтоосон. Иймд эдгээр хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэхгүй байна. Түүнчлэн санал дурдсанаар зөвшөөрөл олгох зохицуулалт хуулийн төсөлд тусгаагүй болно. 3.Хуулийн төсөлд нийтлэг зохицуулалтыг тусгасан бол холбооны засаглалтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг холбоо өөрийн дүрмээр зохицуулахаар
--	-----------------------------	---	---

	хэрэгжүүлэх ба санхүүжилт авсан хүрээнд холбогдох Засгийн газрын байгууллагад тайлагнаж байх талаар зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай. 3.Хуулийн төсөлд холбоодын зохион байгуулалт, бүтэц, үйл ажиллагааны талаар нарийн тодорхой зааж өгсөн нь нэг талаас холбоодод сайн чиглэл өгөх боловч нөгөө талаас дүрмээр зохицуулагдах нарийн заалтуудыг оруулсан нь холбоодыг хэт хязгаарлах, хайрцаглах талтай байгааг анхаарч үзэх хэрэгтэй. 4.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл нь холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд туссантай адилаар төрөөс холбоог хэт хамааралтай байхаар харагдаж байна. Холбоо нь татварын ерөнхий хуулийн дагуу санхүүгийн тайлангуудаа жил болгон тайлагнадаг. Давхар уг зөвлөлд тайлагнах нь шаардлагагүй бөгөөд зөвхөн төрөөс санхүүжилт, санхүүгийн дэмжлэг авсан болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлсэн тохиолдолд тухайн хүрээний үйл ажиллагааны ба санхүүгийн тайланг хүргүүлдэг байхаар тусгах 5.Төслийн танилцуулгад “холбооны тодорхой орлого, хандивыг татвараас чөлөөлөх, бусад татвараас хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх дэмжлэгүүд үзүүлэх” талаар дурдсан боловч хуулийн төсөлд үүнтэй холбоотой ямар нэг зохицуулалт оруулаагүй байгааг анхаарах нь зүйтэй. Хуулийн төслүүдийн тодорхой зүйл заалтуудад өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна. Хавсралт санал: Нэг.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд: 1. Төслийн 3.1.Үйлдвэрчний эвлэл, Улаан загалмай, Худалдаа аж үйлдвэрийн танхим.... холбоо зэрэг бусад хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулах бөгөөд энэ хууль хамаарахгүй гэж өөрчлөн найруулах, 2. Холбооны санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой байлгахын тулд төслийн 6.1 дэх хэсгийн “20 хувь” гэснийг “30 хувь” болгож өөрчлөх,	нээлттэй тусгасан болно. Саналыг тусгаагүй. 4.Хуулийн төсөлд холбоо нь зөвхөн нийтэд тустай үйл ажиллагааг явуулж байгаа болон төрийн зарим чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа тохиолдолд санхүү, татварын тайланг холбогдох байгууллагад хүргүүлж, дүгнүүлэх, нээлттэй байршуулах үүргийг тусгасан болно. Саналыг тусгаагүй. 5.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т татварын хөнгөлөлтийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу олгохоор заасан болно. Саналыг тусгаагүй. Хавсралт: Нэг.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл: 1. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгайлсан хуулиар зохицуулж байгаа харилцааг тухайн хуулиар зохицуулах бөгөөд харин тусгайлсан хуулиар зохицуулаагүй нийтлэг харилцааг дээрх хуулиар зохицуулахаар төсөлд тусгасан. Түүнчлэн зарим холбоо, сангийн дотоод засаглалтай холбоотой асуудлыг өөрсдийн дүрмээр зохицуулахаар нээлттэй үлдээсэн болно. Санал нь хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй байна. Саналыг тусгаагүй. 2.Эрх зүйн төлөвшилт өндөр хөгжсөн улс орнуудын хуульд ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үндсэн үйл ажиллагааныхаа 10-15
--	--	--

	3. Төслийн 6.4. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх шийдвэрийг тухайн холбооны дүрэмд заасан эрх бүхий этгээдэд гаргана. Гэж заасан нь тодорхойгүй байна. 4.Төслийн 5.1.Холбоо нь үйл ажиллагаагаа төрөөс хараат бусаар, өөрийгөө удирдах хууль тогтоомжийн хүрээнд явуулна гэсэн зарчимтай төслийн 6.3 дахь хэсэг зөрчилдөх тул хасах, 5.Төслийн 7.1 дэх хэсгийн “35.3” гэснийг “35.2” гэж өөрчлөх, 6.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Холбоогоор төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх” гэснийг “Холбоо нь төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх” гэж өөрчлөх, 7. Төслийн 9.1.3-т “иргэний төлбөрийг төлөх” гэдэг нь тодорхойгүй байгааг тодорхой болгох, 8.Холбооны чадамжид сөргөөр нөлөөлөх тул өргөн хүрээгээр заахгүй байх үүднээс төслийн 9.2.2. “Улс төрийн намын удирдлага, намын санхүүгийн албаны дарга түүнтэй адилтгах албан тушаалтан” гэснийг “Улс төрийн намын дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, намын санхүүгийн албаны дарга;” гэж өөрчлөн найруулах, 9.Төслийн 11.2.14 дэх заалтыг “Төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой төсөв, санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилт болон зарцуулалтыг олон нийтэд нээлттэй тайлагнах журам” гэж өөрчлөх, 10.Бизнес эрхлэгчдийг нэгтгэсэн холбоо буюу хуулийн этгээд байгуулахыг хязгаарлахгүйн үүднээс төслийн 12.3.2. Төрийн байгууллага, улсын төсөв болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар, нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс бусад хуулийн этгээд Нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэдгийг хасах саналтай байна. 11.Төрийн зарим чиг үүргийг шилжүүлэн авсантай холбоотой үйл ажиллагааныхаа хүрээнд санхүүгийн тайлан ба үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй тайлагнах хүрээнд зөвхөн тухайн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нээлттэй байлгах нь зүйтэй тул төслийн 13.3 дахь хэсгийг “Холбоо нь гэрээний дагуу төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэсэн бол гүйцэтгэсэн ажлын хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гэрээнд заасан журмаар тухайн гэрээ байгуулсан төрийн байгууллага	хувьд аж ахуйн үйл ажиллагааг явуулж болохоор заасан бөгөөд энэхүү жишгийн баримталсан болно. Түүнчлэн ашгийн төлөө бус хуулийн этгээд нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахгүй байх, ашиг хуваарилахгүй байх үндсэн зарчимтай. Иймд дээрх зарчим, олон улсын жишиг, ашгийн бус байгууллагын санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой байлгах үүднээс аж ахуйн үйл ажиллагааг явуулж болох дээд хэмжээг 50 хувиар тогтоосон болно. Саналыг тусгах боломжгүй. 3.Холбоо өөрийн дүрмээрээ эрх бүхий этгээдийг тогтооно. Холбоо бүр харилцан адилгүй болно. Саналыг тусгаагүй. 4. Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг бол зөвхөн хуулийн төслийн 6.1-д заасан 50 хувийг хэрхэн тогтоох талаарх журмыг батлах субъектыг тодорхойлсон тул зөрчилдөхгүй бөгөөд саналыг тусгах боломжгүй байна. 5.Саналыг тусгасан. 6.Саналыг тусгасан. 7.Холбоо нийтэд тустай үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааны иргэний төлбөрийг холбооны хөрөнгөөр төлөхийг хориглохоор заасан. Энэ нь холбооны хөрөнгө хувь хүний, хувь компанийн хөрөнгө биш бөгөөд дүрэмд заасан үйл ажиллагаанд зарцуулах ёстой. Саналыг тусгаагүй. 8.Хуулийн төслийн үзэл баримтлалд нийцэхгүй. Саналыг тусгаагүй. 9.Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлсэн холбооны үйл ажиллагаа, санхүүжилт нь хуулийн төсөлд зааснаар нээлттэй байлгах тул давхардсан байна. Саналыг тусгаагүй.
--	--	---

	болон Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд дараа жилийн эхний улиралд багтаан хүргүүлнэ” гэж өөрчлөх, 12. Мөн төслийн 13.7 дахь хэсгийг “Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан холбоо нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэсэн бол гүйцэтгэсэн ажлын хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангаа олон нийтэд нээлттэй байлгана.” Гэж өөрчлөх, 13.14.2-т заасан Холбоонд өгсөн хандив, гэрээслэлээр өвлүүлсэн эд хөрөнгө “нэг сая” төгрөгөөс дээш гэдгийг “гурван сая” төгрөгөөс дээш гэж өөрчлөх, 14.Төлөөлөлтэй холбоотой харилцааг Иргэний хуулийн 62- 70 дугаар зүйлээр зохицуулсан тул 16.2 дахь хэсгийг хасах, 15. Төслийн 16.2.2-т заасан “мэдсэн” гэдэг ойлголтыг тодорхой болгох, Мэдсэн гэдгийг хэрхэн тогтоох вэ, Мэдээллийн урсгалыг холбооны удирдлагын зүгээс байнга хянах боломжгүй юм. 16.Төслийн 20.5-д заасан шүүхийн харьяаллын талаар тодруулах, 17.Саналын эрхийг хязгаарлах нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг зөрчих тул төслийн 23.4-т заасан “санал өгөх эрхийг хязгаарлахыг” гэдгийг “санал өгөхөөс татгалзах эрхтэй байхаар” өөрчлөх, 18.Удирдах зөвлөлийн дарга, гишүүн үүргээ гүйцэтгэснийхээ төлөө тухайн холбооноос цалин, урамшуулал авах эсэхийг дүрмээрээ шийдэх асуудал тул 24.8 дахь хэсгийг хасах, 19.Төслийн 26.1 дэх хэсэгт “26.1.4. Гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах;” гэж нэмэх, 20.Хяналтын хорооны гишүүдийг нөлөөлөлд автахаас сэргийлж төслийн 28.2 дахь хэсгийн “гүйцэтгэх албан тушаалтан” гэсний дараа “нэг гэр бүлийн гишүүд болон төрөл садангийн хүн, хамт ажилладаг 2 ба түүнээс дээш гишүүдийг оролцуулах” гэж нэмэх, 21.Төслийн 32.1 дэх хэсгийг “Татан буугдаж байгаа холбооны хөрөнгөөс шаардах эрх бүхий харилцагчийн үүргийн гүйцэтгэлийг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг холбоог үүсгэн байгуулагчдад оруулсан хөрөнгийг хэмжээгээр хуваарилна” гэж өөрчлөн найруулах, 22.Дүрмээр нарийвчлан зохицуулах асуудал тул төслийн 32.2 дахь хэсгийг “Хэрэв үүсгэн байгуулагчид байхгүй тохиолдолд холбооны	10.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3.2 дахь заалт нь төрийн байгууллагад хамааралтай заалт болно. Өөрөөр хэлбэл төрийн байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар зэрэг нь холбоог үүсгэн байгуулж болохгүй. Харин бизнесийн байгууллага буюу ашгийн төлөө хуулийн этгээд нь энэ хуулийн төслийн 33 дугаар зүйлд заасны дагуу эдийн засгийн холбоог байгуулж болно. Саналыг тусгаагүй. 11.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь бизнесийн, ашгийн төлөө байгууллага биш бөгөөд олон улсын жишигт үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан нь нээлттэй байдаг. Энэ нь ашгийн төлөө бус үйл ажиллагааг явуулдаг, олон нийтээс хандив цуглуулдаг зэрэгтэй холбоотой юм. Нөгөө талаас хууль бус үйл ажиллагааг явуулахгүй байх, хандив тусламжийг зөвхөн дүрэмдээ заасан нийтийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд зарцуулах, ашиг олох үйл ажиллагааг явуулахгүй байхтай холбоотой юм. Иймд саналыг авах боломжгүй, үзэл баримтлалд нийцэхгүй байна. Саналыг тусгаагүй. 12.Үзэл баримтлалтай нийцэхгүй. Саналыг тусгаагүй. 13.Төрийн бус байгууллагын тухай хуульд 700 000 төгрөгөөс дээш хандив, өвийг өгсөн хүний талаар тайландаа заавал мэдүүлэхээр заасан байдаг. Энэхүү зохицуулалтыг хэвээр хадгалсан бөгөөд мөнгөн дүнгийн хэмжээг 1 сая төгрөг байхаар тогтоосон болно. Саналыг тусгаагүй.
--	---	--

	эрх барих байгууллага нь үлдсэн хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн холбоонд шилжүүлэхээр шийдвэрлэж болно.” гэж өөрчлөн найруулах, 23. Дүрмээр нарийвчлан зохицуулах тул 32.3 дахь хэсгийг хасах, 24.Төслийн 32.2-т “олонх” гэдгийг яаж тогтоох нь тодорхойгүй байгааг тодорхойлох, 25.Төслийн 33.4 дэх хэсгийн “мэргэжилтэн” гэдгийг тодорхойлох, 26.Холбооны хараат бус байдалд нөлөөлөх тул төслийн 33.10-т заасан журмыг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран батлахаар өөрчлөх, 27.Төслийн 38 дугаар зүйлд “Хүлээн зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллага, холбоодыг оролцуулах” гэж нэмэх, 28.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг тодорхой зааж өгөх, 29.Төслийн 41.1 дэх хэсгийг “Нэршлийн зөрчилд орсон холбоо нь 2 жилийн хугацаанд багтаан улсын бүртгэлд дахин бүртгүүлсэн байна.” гэж өөрчлөн найруулах,	14.Иргэний хуулийн 62-70 дугаар зүйлд итгэмжлэлээр төлөөлөх, төлөөллийг бусдад шилжүүлэх талаарх хуульд тусгайлан заагаагүй, ерөнхий зохицуулалтыг заасан бол Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд холбоог хуулийн дагуу хэн шууд төлөөлөх талаар тусгасан нарийвчилсан зохицуулалт бөгөөд төсөлд саналыг тусгаснаар харилцаа зохицуулалтгүй, хийдэл үүсэхээр байх тул саналыг тусгаагүй болно. 15.Холбооны үйл ажиллагаа шийдвэр, хэлцэл зэрэг бичгээр хийгдэх, албан бланк, тамга тэмдэг зурагдах тул удирдлага мэдсэн байх боломжтой тул саналыг тусгах шаардлагагүй байна. 16.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу шүүхийн харьяаллаар шийдвэрлэнэ. Саналыг тусгаагүй. 17.Саналыг хэсэгчлэн тусгав. 18.Хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй. Саналыг тусгаагүй. 19.Холбооны дүрмээр зохицуулагдаж байгаа тул гүйцэтгэх удирдлагатай гэрээг байгуулах шаардлагагүй. Саналыг тусгаагүй. 20.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулснаас бусад холбооны үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг холбооны дүрмээр зохицуулж болно. Саналыг тусгаагүй. 21.Холбооны эд хөрөнгө нь тухайн хандив тусламж, гишүүний татвар гэх мэт хөрөнгөөс бүрдэх бөгөөд үүнийг холбоо үүсгэн байгуулагчид хувааж авна гэдэг бол зүй бус үндсэн зарчимтай нийцэхгүй,
--	--	--

			ашгийн бус хуулийн этгээдэд байж болохгүй үйлдэл бөгөөд хуулийн төслийн бусад зүйл, хэсэг, заалттай зөрчилдөж байна. Үзэл баримтлал болон ашгийн бус хуулийн этгээдийн гол зарчим, шинжтэй нийцэхгүй болно. Саналыг тусгаагүй. 22. Үзэл баримтлалд нийцэхгүй зохицуулалт тул саналыг тусгах боломжгүй. 23. Нийтлэг зохицуулалт тул хуульд зааж өгөх нь зүйтэй болно. Иймд саналыг тусгах боломжгүй. 24. Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.2-т “олонх” гэдэг үг ороогүй болно. Саналыг тусгаагүй. 25. Мэргэжлийн холбооны гишүүн нь тухайн салбарын мэргэжилтэн байхыг шаардаж байгаа бөгөөд энэ нь тодорхой байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмыг баримталсан болно. 26. Хуулийн төсөлд мэргэжлийн холбоог сонгон шалгаруулах журмыг Монгол Улсын Засгийн газар журмыг баталснаар нөлөөлөлд орохгүй тул саналыг авах шаардлагагүй байна. 27. Саналын үндэслэл болон хаана оруулах нь тодорхойгүй тул саналыг оруулаагүй болно. 28. Саналыг тусгасан болно. 29. Хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд нийцүүлсэн тул саналыг авах боломжгүй байна.
5	Монголын өмгөөлөгчдийн холбоо 2021,04,06	Төслийг дэмжиж байна.	Дэмжсэн

	01/330		
6	Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо 2021.04.04 21/21 Цахимаар ирүүлсэн.	Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл: 1.Төслийн 10.5 заалтад МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ, НЭГДСЭН гэдэг нэрийг салбар салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн нэг л Холбоо хэрэглэх эрхтэй байна. /Бүгд ижил түвшний нэр авч хэн нь олныг хамарсан үйл ажиллагаа явуулж буй хэн явуулж чадахгүй байгаа ялгах аргагүй болно/. 2.Төслийн 4.2 заалтад нэг сая төгрөгөөс дээш гэдгийг 3 сая гэж өөрчлөх 3.Төслийн 41.1 заалтад “Хууль батлагдсанаар Нэршлийн зөрчилд орсон Холбоо нь 2 жилийн хугацаанд улсын бүртгэлд дахин бүртгүүлсэн байна.” гэж өөрчлөх. /Хуулийн зөрчилгүй бол дахин бүртгүүлж бужигнуулах; нэрээ булаацалдах шаардлагагүй гэж үзэх- байна./.	1.Хуулийн шилжилтийн үеийн зохицуулалтаар Монголын, Үндэсний, Нэгдсэн гэсэн үг орсон нэртэй холбоо шинэчилсэн бүртгэлд орох бөгөөд хуулийн төсөлд заасан журмын дагуу дээрх үг орсон нэртэй байна. 2.Одоогийн хуульд 700 000 төгрөг байхаар заасан бөгөөд хуулийн төсөлд 1 сая байхаар тусгасан. Мэдээлэх мөнгө дүнгийн хэмжээ боломжит бага хэмжээнд байх нь зүйтэй. 3.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд зааснаар холбоо нь бүртгэгдсэн холбоо, мэргэжлийн холбоо, эдийн засгийн холбоо гэх зэргээр ялгаж өгөх шаардлагатай тул шинэчилсэн бүртгэлд бүртгэгдэх болно.
7	Монгол хүнсчдийн холбоо 2021.04.23 66	Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд: 1.Төслийн 6-р зүйлд заасан аж ахуйн үйл ажиллагаа гэдэгт яг юуг ойлгох талаар дэлгэрүүлж тусгах, шаардлагатай бол нэр томьёо хэсэгт тусгах. - Ашгийн төлөө үйл ажиллагаа гэж ойлгох болох эсэх; 2.Төслийн 6.1-д хоршоо үйл ажиллагааны 20%-иас хэтрүүлэхгүй аж ахуйн үйл ажиллагаа явуулна гэсэн байна. Уг хувийг яаж тооцох вэ?, юуг үндэслэн 20%-иас хэтрээгүй гэж үзэх вэ гэдэг нь тодорхойгүй байна; 3.Төслийн 8.1-д “Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын зарим чиг үүргийг холбоогоор хуульд заасны дагуу, эсхүл гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно” гэж заажээ.	Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл: 1.Аж ахуйн үйл ажиллагаа гэдгийг Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуульд тодорхойлж өгсөн тул дахин тайлбар, тодорхойлолт хийх шаардлагагүй байна. Саналыг тусгаагүй. 2.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3-т аж ахуйн үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагааны 50 хувиар тооцох аргачлалыг батлахаар заасан болно. Саналыг тусгаагүй. 3., 4.Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад хуульд заасан тохиолдолд

	Захиргааны ерөнхий хуулийн 8.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж тусгасан. Хуульд заасан тохиолдолд захиргааны зарим чиг үүргийг гэрээгээр бусдад шилжүүлэн гүйцэтгэх агуулгатай тул хуулийн төсөлд тусгасан хууль, эсхүл гэрээний үндсэн дээр заах нь Захиргааны ерөнхий хуультай зөрчилдөж байгаа ба “хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр” гэж өөрчлөх; 4.Төслийн 8.3-д “Холбоогоор гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийн жагсаалтыг Засгийн газар батална” гэж заажээ. Дээрх заалтыг хэрэгжүүлэхэд тухайн чиг үүргийг бусдад шилжүүлж болох талаар хуульд заасан тохиолдолд засгийн газар баталж болно. Хуульд заагаагүй хүрээнд Засгийн газар жагсаалтыг батлах боломжгүй. Захиргааны ерөнхий хуулийн 8.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж тусгасан; 5.Төслийн 16.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол холбоог удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал тус тус төлөөлнө”, 26.1.2-д “бүх гишүүдийн хурлаас олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөх” гэж тус тус заажээ. Компанийн тухай хуульд компанийг зөвхөн гүйцэтгэх удирдлага төлөөлөхөөр заасан ба өмнө нь итгэмжлэлгүйгээр төлөөлөх чиглэлээр ТУЗ-ын дарга, гүйцэтгэх удирдлагын хооронд давхардал үүсэж байсан тул шинэ компанийн хуулиар дээрх давхардлыг арилгаж зохицуулсан туршлага байдаг. Хэрэв ТУЗ-ын дарга, гүйцэтгэх захирал 2 тухайн асуудлаар саналын зөрүүтэй тохиолдолд аль шийдвэрийг хүлээн авах талаар хүндрэлтэй асуудал үүсэж болзошгүй. (Цаашид холбооны үйл ажиллагааг чадавхжуулах, идэвхжүүлэх нь уг хуулийн агуулга тул холбооны ач холбогдол, байнгын үйл ажиллагаа, цар хүрээ нэмэгдэнэ) Мөн төслийн 15.3-д холбоог гүйцэтгэх захирал төлөөлнө гэж заасан байдаг. ТУЗ-ын дарга давхар холбоог төлөөлөхөөр заасан итгэмжлэлгүйгээр төлөөлөх давхардал үүсгэж байгаа тул ТУЗ-ын дарга төлөөлөх заалтыг хасах;	шилжүүлэхээр байгаа бөгөөд харин хуульд шилжүүлэхээр заасан боловч хэрхэн яаж, хэдий хугацаагаар шилжүүлэх асуудлыг гэрээгээр нарийвчлан тохирохоор байгаа болно. Түүнчлэн салбарын хуулиудад шилжүүлж болохоор заасан чиг үүргээс боломжтой чиг үүргийг Засгийн газрын тогтоолоор жагсаалтыг батлах юм. Харин дараагийн ээлжид жагсаалтад ороогүй чиг үүргийг шилжүүлэх тохиолдолд Засгийн газрын тогтоолоор шилжүүлэх боломжтой жагсаалтад оруулах юм. Саналыг тусгаагүй. 5.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1-д “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж тодорхойлж өгсөн бөгөөд хуульд буюу 26 дугаар зүйлийн 26.1.2-т бүх гишүүдийн хурлаас олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөхөөр заасан. Өөрөөр хэлбэл бүх гишүүдийн хурлаар холбооны дүрэмд удирдах зөвлөлийн төлөөлөх эрх хэмжээг зааж өгсөн. Харин тусгайлан заасан эрх хэмжээнээс бусад эрх хэмжээний хүрээнд гүйцэтгэх удирдлага төлөөлөхөөр заасан болно. Түүнчлэн өөрийгөө удирдах зарчмын хүрээнд холбоо өөрийн дүрмээрээ төлөөлөх эрх бүхий этгээдээ нарийвчлан зааж өгөх ёстой. Саналыг тусгаагүй. 6.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2-т шилжүүлж болно гэж заасан бөгөөд энэ бүх эрхийг шилжүүлэх ойлголт биш болно. Зөвхөн тусгайлсан хуульд заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдэд шилжүүлж болохоор заасан чиг үүргийг шилжүүлэх юм. Саналыг тусгаагүй.
--	--	---

	6.Төслийн 16.2-д “Энэ хуулийн 16.1-д заасан этгээд нь холбоог төлөөлөх эрхийг бусдад бичгээр шилжүүлж болно” гэж тусгажээ. Гүйцэтгэх удирдлагын бусдад шилжүүлж болохгүй эрх бас байдаг. Гэтэл бүх эрхийг бусдад шилжүүлж болохоор заасан нь цаашид үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж болзошгүй. Төслийн 17.3-д “Энэ хуулийн 17.1.3, 17.1.4, 17.1.6-д заасан холбооны бүх гишүүдийн хурлын бүрэн эрхийг холбооны дүрмээр удирдах зөвлөлд шилжүүлж болно” гэж заажээ; 7.Төслийн 17.1.2-д удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх, огцруулах эрхийг бүх гишүүдийн хуралд олгосон байна. Энэхүү эрхийг төслийн 17.3-д заасан удирдах зөвлөлд шилжүүлж болох эрхийн агуулгад багтааж болохоор зохицуулалтыг хийх (Удирдах зөвлөлийн гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх, хүндээр өвдөх, нас барах гм тохиолдлууд байдаг тул тэр бүрд бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах нь ажиллагаа ихгүй, ач холбогдол багатай байх, зардал ихтэй байх тохиолдлууд үүсэх үр дагавартай) 8.Төслийн 18.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол холбооны гишүүнчлэл сайн дурын байна” гэж заажээ. Холбооны гишүүн нь хувь хүн болон хуулийн этгээд, бусад холбоод байж болох талаар тусгах (Жнь: Хүнсчдийн холбоонд хувь хүн гэхээс илүү хүнс үйлдвэрлэгч хуулийн этгээд өөрийн нэрээр гишүүнээр элсдэг гм) 9.Төслийн 22.9-д “Шүүх энэ хуулийн 22.8-д заасан гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл удирдах зөвлөлийн хурлыг дахин хуралдуулах шийдвэр гаргаж, үүнтэй холбогдон гарах зардлыг буруутай этгээдээр төлүүлнэ.” гэж тусгажээ Шүүхээс ямар шийдвэрийг гаргахыг заах нь шүүхийн бүрэн эрхэд халдаж байгаа бөгөөд тухайн заалтыг шүүхэд гомдол гарган шийдвэрлүүлнэ гэсэн ерөнхий утгаар оруулах хэрэгтэй. Шүүхийн бүрэн эрхэд халдах нь үндсэн хууль зөрчсөн гэж маргаан үүсгэж болзошгүй.	7.Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.3-т бүх гишүүдийн хурал нь удирдах зөвлөлд гишүүн элсүүлэх, гишүүнээс хасах, түдгэлзүүлэх эрхийг холбооны дүрмээр шилжүүлж болохоор заасан тул саналыг тусгах шаардлагагүй байна. 8. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “холбоо” гэж нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг хэлэхээр тодорхойлсон бөгөөд этгээд гэдэг хүн, хуулийн этгээд орно. Иймд саналд заасны дагуу тусгайлан заах шаардлагагүй байна. 9.Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.9-д шүүхийн шийдвэр гаргах үндэслэл, гаргах шийдвэрийн талаар заасан болно. Бусад хуульд нийцүүлэн томъёолсон болно. Саналыг тусгаагүй. 10.Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1.3-т холбооны дүрэмд заасан бусад эрх гэж гүйцэтгэх захиралд олгох эрхийг заахаар тусгасан болно. Иймд холбоо тухайн гүйцэтгэх захиралд ямар эрх хэмжээ олгохыг өөрийн дүрмээрээ олгохоор заасан тул саналыг тусгаагүй болно. 11.Саналын дагуу “татан буулгах албадлагын арга хэмжээ” гэж тусгав. Нэмэлт санал:
--	---	---

		10.Төслийн 27.1.1-д “удирдах зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөн гэрээ, хэлцэл хийх” гэж тусгажээ. Дээрх заалтыг өргөжүүлж, “Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, холбоог төлөөлөх зэргээр холбооны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна” гэж тусгах 11.Төслийн 31.1.4-д “шүүхийн шийдвэрээр Эрүүгийн хуульд заасан татан буулгах арга хэмжээ авагдсан” бол холбоог татан буулгахаар заажээ. -татан буулгах албадлагын арга хэмжээ гэж тусгах -Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл байгуулагдаагүй үед гишүүдийн сонгон шалгаруулалтыг ямар журмаар хэрхэн сонгон шалгаруулж байгуулах асуудлыг талаар тусгах /төсөлд нэгэнт байгуулагдсаны дараах сонгон шалгаруулалтын асуудлууд тусгагдсан байна/ -Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн ажлын албаны санхүүжилт нь гишүүдийн хандив, тусламж, хүү, өвлөсөн хөрөнгөнөөс бүрдэнэ гэж заасан нь тодорхойгүй байна. Дээрх байдлаар ажлын албаны хэвийн үйл ажиллагааг явуулахад хангалттай санхүүжилт бий болгох магадлал бага. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжиж болно гэж заасан нь санхүүжилтийг тусгахгүй бол үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрэх магадлалтай тул тодорхой болгох шаардлагатай. Нэмэлт саналууд 1. Дээрх хууль гарахтай уялдуулан Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох талаар заалт оруулах Тухайлбал 1.1.Үйлдвэрлэлийн шинээр эрхлэх үед мэргэжлийн холбоо тухайн аж ахуй нэгжийг шалгаж, санал дүгнэлтээ төрийн байгууллагад хүргүүлэх; 1.2.Зохистой дадлыг нэвтрүүлсэн талаар шалгаж баталгаажуулах; 1.3.Стратегийн хүнсийг экспортлох, импортлох үйл ажиллагаатай холбоотой хяналт хэрэгжүүлэх; 1.4.Хүнсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнд багтах гм.	Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйл болон 14 дүгээр зүйлд төрийн бус байгууллагаар хүнсний хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлж болохоор заасан байна. Саналыг тусгаагүй.
--	--	---	--

8	Монголын хүний эрхийн форум 2021.04.20 15	Юуны түрүүнд, иргэний нийгмийн, тэр дундаа засаглал, хүний эрхийн чиглэлээр ажилладаг, төрийн үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийдэг олон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих гэхээсээ илүү хумих, хязгаарлах агуулгатай хууль боловсруулагдаж байгаад бидний зүгээс санаа зовниж буйгаа илэрхийлье. Нийтэд тустай үйл ажиллагааны, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн үндсэн үзэл баримтлал нь иргэдийн нийгмийн идэвхийг хөхүүлэн дэмжиж улсын, нутгийн хөгжлийн удирдлага, үйл явцад ухамсартайгаар оролцохыг нь өрнүүлсэн, иргэний нийгмийн байгууллагын хөгжил, үйл ажиллагааны үр нөлөө, засаглал, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн таатай орчин, бодлогын хөшүүрэг болох ёстой юм. Гэтэл одоогийн боловсруулсан үзэл баримтлал нь иргэдийн идэвх санаачлага, хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагааны талбар болсон иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудын хэвшлийг үндэсний аюулгүй байдалд заналхийлж буйгаар төсөөлөн эдгээр байгууллагыг төрийн зүгээс хянах, үүний тулд санхүүжилт, дэмжлэгийг төрийн мэдэлд төвлөрүүлэх өнцгөөс бичигдсэнд харамсаж байна. 1997 онд батлагдсан, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4-р зүйлд ТББ-ыг “...үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага” гэж тодорхойлсон байдаг. Энд дурдагдсан “төрөөс хараат бус байх”, “өөрийгөө удирдах” гол 2 зарчим дээрх хуулиудын үзэл баримтлалд орхигдсон нь Монгол улсын хувьд ухралт болох улмаар ҮХ-ийн ардчиллыг бэхжүүлэх үзэл санааг зөрчинө гэж бид үзэж байна. Иймд дээрх багц хуулийн үзэл баримтлалыг боловсруулахад иргэний нийгмийн байр суурийг харгалзан үзэж, олон хэлбэрийн төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллах замаар нийтэд тустай үйл ажиллагааг олон улсын дэвшилтэт чиг хандлагад нийцүүлэн тодорхойлж зохицуулах, төрийн бус байгууллагын ангиллыг олон улсын ангилалтай дүйцүүлж төрийн бус байгууллагын олон хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, тэдэнтэй бодитой хамтран ажиллах, төрөөс хараат бус байж өөрийгөө удирдах зарчмыг хэрэгжүүлэх, иргэний нийгмийн байгууллага	Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан зохицуулалтыг оруулснаас холбооны үйл ажиллагааг хязгаарлах, тэднийг төрийн зүгээс хянах гэсэн үзэл баримтлал, зохицуулалт байхгүй. Түүнчлэн төрөөс хараат бусаар өөрийгөө удирдах зарчмыг төсөлд тунхаглан оруулж, хуулийн төслийг боловсруулсан болно. Тухайлбал Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлд төр, холбооны хоорондын харилцаанд холбоо нь үйл ажиллагаагаа төрөөс хараат бусаар өөрийгөө удирдан хууль тогтоомжийнх хүрээнд явуулахаар заасан. Хуулийн төсөлд холбоо нь өөрийгөө удирдах боломжийг нийтлэг байдлаар тусгаж өгсөн бөгөөд хуульд зааснаас бусад харилцааг холбоо өөрийн дүрмээр зохицуулахаар тусгасан. Хуулийн төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг цохон дурдсан. Энэ нь холбоонд төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх гол үндэслэл болж байгаа болно. Харин Хүний эрхийн форумын саналд дурдсанчлан ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үндэсний аюулгүй байдалд занал хийлж байгаа төрийн зүгээс хянах гэсэн ойлголтыг илэрхийлээгүй болно.

		болон секторын хөгжлийг дэмжих зэрэг зарчмын шинжтэй олон санал байгааг ажлын хэсгийн хүрээнд хүлээн авч одоогийн багц хуулийн төслийг үзэл баримтлалын түвшинд эргэн харж өөрчлөх шаардлагатай байна. Үүний зэрэгцээ ФАТФ-ын заавар, бодлогыг улс орнууд хэрэгжүүлэх явцад олон чиглэлээр, түүний дотор хүний эрх, иргэний нийгмийн байгууллагуудын хувьд гаж үр дагавар гарч буйг ФАТФ өөрөө хүлээн зөвшөөрч уршгийг залруулах арга хэмжээг авч эхэлснийг дээрх хууль тогтоомжийг эцэслэн боловсруулахад харгалзах зайлшгүй шаардлагатайг Сайд Танд сонордуулж байна. Эцэст нь иргэний нийгмийн үйл ажиллагааг зохицуулах гол бодлого боловсруулах үйл явцад тэдний өргөн оролцоог хангах тал дээр анхаарч ажиллана гэж найдаж байна. Бидний зүгээс ажлын хэсэгт нэмэлтээр оруулах салбарын туршлагатай төлөөлөгчдийн нэрсийг 2021 оны 2-р сарын 16-нд, энэхүү захидалд хавсаргасан саналын жагсаалтыг 2021 оны 3 сарын 4-ний өдөр Ажлын хэсэгт цахим шуудангаар хүргүүлсэн бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэсэн эсэх талаар хариу хүлээж байгааг энэ ялдамд уламжилъя. Захидалд иргэний нийгмийн байгууллагуудын хуулийн төслүүдийн талаарх байр суурийг илэрхийлэх саналын жагсаалт, Иргэний нийгмийн орон зайг үнэлэх судалгааны тайлангийн төслийг хавсаргав.	Түүнчлэн хуулийн төслийг боловсруулахад гадаад улсын хууль тогтоомжийг судалж, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэр, нийтэд тустай үйл ажиллагаа зэргийг олон улсын жишигт нийцүүлэн төрөл хэлбэрээр ялган тодорхойлсон. Саналыг тусгаагүй.
9	Монголын гимнастикийн холбоо 2021.04.09 1/017	1.Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төрийн бус байгууллагын тухай хуулийг сайжруулсан гэж үзэж байна. Ялангуяа Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр. конвенцоор дагаж мөрдөх үүргийг тусгаж өгснөөрөө дэвшил болсныг уламжлах нь зүйтэй юм. Допингийн асуудлыг хамруулахад дагаж мөрдөх хөшүүрэг болох. 2.Хуулийн төсөлд “Биеийн тамир” 'Нийтийн биеийн тамир’, “Спорт”, “Спортын холбоо -дын талаар маш учир дутагдалтай орсон байна. Тодруулбал 35.2, 35.2.1-35.2.16 дугаар заалтуудад “Биеийн тамир”, “Нийтийн биеийн тамир”, “Спорт”, “Спортын холбоо”-д гэсэн тус тусдаа, өөрсдийн ухагдахуунтай 4 салбар ойлголтыг орхигдуулжээ.	1.Дэмжсэн санал. 2.Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь холбооны нийтлэг зохицуулалтыг тусгасан хууль болно. Харин спортын холбоо гэдгээр тусгайлан зохицуулалтыг тусгах боломжгүй юм. Харин нийтэд тустай үйл ажиллагаанд “нийтийн биеийн тамир” гэдэг нэр томъёогоор тодорхойлсон байгаа болно. 3.Хуулийн төслийн 38 дугаар зүйлийн 38.3.4-т “сонирхогчийн биеийн тамир” гэснийг “спорт” гэж өөрчлөв. Саналыг тусгасан.

		3.Төслийн 38.3.4-т сонирхогчийн спорт гэж оруулсан нь явцуу, өрөөсгөл ойлголт тул тодорхой зааж өгөх хэрэгтэй. Мэргэжлийн болон сонирхогчийн спортын төрлүүдийг тодорхой зааж өгснөөр хөгжих гол суурь нь болно. Энэхүү хуульд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж чадаагүй асуудлыг давхар оруулж өгснөөрөө энэ хуулийн хэрэгжилт, оршин тогтнох үндэс нь болно. Жишээ нь: Гадны мэргэжилтэн багш-дасгалжуулагч нарыг урьж ажиллуулахад маш хүндрэлтэй байдаг холбогдох зөвшөөрлийг авахад хөнгөлөлттэй байх зарчмыг тусгах, ингэснээрээ эрүүл мэнд, боловсрол, бие бялдрын боловсрол биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг дэмжиж төрийн үүрэх ачааг багасгах сайн талтай. Монголын гимнастикийн холбооноос дээрх саналуудыг албан ёсоор хүргүүлж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд ЗГТА - Биеийн Тамир, Спортын Улсын Хороо, Спортын холбоодтой хамтарсан цахим хэлэлцүүлгийг хийх боломжтой байгааг хүлээн авна уу.	
10	1.Ардчиллын боловсрол төв (ДЕМО) 2.МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ 3.Монголын эмнести интернэшнл ТББ 4.Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо 5.Нээлттэй нийгэм форум 6.Транспаренси Интернэшнл Монгол	Тус хуульд өгөх саналууд голчлон үзэл баримтлалын хүрээний зарчмын санал, шүүмж байх бөгөөд дараах байдлаар бүлэглэн хүргэхээр бэлдлээ. Үүнд: • Эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулах • Төрийн бодлого үйл ажиллагаанд оролцох тэгш боломж, оролцоог хангах • Иргэний нийгмийн төлөвшлийг дэмжих • Иргэний нийгмийн санхүүжилтийн хөшүүрэг, зохицуулалт • Хууль боловсруулах үйл явцад иргэний нийгмийн оролцоо, зөвшилцөл Эвлэлдэн нэгдэх эрхийг хангах: - Үзэл баримтлалын хувьд тус хуулийн гол зорилго нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах тухай байх атал үзэл баримтлалын баримт бичиг үндэсний аюулгүй байдлын бодлогыг дурдаж эхэлж байгааг хууль санаачлагчийн санаа зориг нь хүний эрхийн	-Эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулах хүрээнд: Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон төслийн үзэл баримтлалыг нэн тэргүүнд Монгол Улсын Үндсэн хуульд заасан эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангах хүрээнд боловсруулсан болно. Харин хуулийн төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг оруулж үндэслэл болгосон нь төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар буюу ашгийн төлөө бус хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бий болгох үндэслэл болгосон.

	Цахимаар ирүүлсэн	баталгаа бий болгохыг чухалчлан авч үзээгүй гэж дүгнэж болохуйц байна. - Иргэний нийгмийн байгууллага төлөвшлийн хувьд органик байдлаар албан бусаар үзэл санаа, итгэл үнэмшлийн үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, зорьж буй өөрчлөлт нь урт удаан хугацаанд тогтвортой үйл ажиллагаа шаардахаар бол зохион байгуулалтад орж ТББ-ын статустай болдог хөгжлийн үе шат бий. Энэ завсрын үед иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хамгаалах нь иргэний нийгмийн төлөвшилд нэн чухал юм. Зохицуулалтын талаасаа энэ үе шатыг хуульд хүлээн зөвшөөрөх нь чухал байна. - Одоогийн ТББ-ын тухай хуулийн зохицуулалтыг салган Холбооны тухай хууль болгон тусад зохицуулахын ач холбогдол, давуу тал харагдахгүй байна. Учир нь дээрх хуулийн төслийн ихэнх заалтууд нь давтагдсан, давхардсан шинжтэй байна. Тэрчлэн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх болон холбоо, санд хориглох үйл ажиллагаанаас бусад ихэнх зохицуулалт нь одоогийн Төрийн бус байгууллагын тухай хуулиас зарчмын онц ялгаагүй байна. - Холбоонд хориглох үйл ажиллагааг бүхэлд нь тэдгээрийн татан буулгах үндэслэл болгосон нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлах эрсдэлтэй байна. Учир нь санхүүгийн тайланг 8 улирал дараалан гаргахгүй байх, улс төрийн намын үйл ажиллагаа хэрэгжүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх, сонгуульд нэр дэвшигчдэд хандив өгөх зэрэг нь байгууллагыг татан буулгах хэмжээний ноцтой зөрчил бус бөгөөд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцож болохоор зөрчлүүд юм. Тэрчлэн дээрх үндэслэлээр холбоог татан буулгах гомдлыг сонирхогч этгээд шүүхэд гаргахаар байгаа нь тодорхойгүй, хэмжүүргүй шалтгаанаар төрийн бус байгууллагыг татан буулгах, улмаар иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлах эрсдэлтэй байна. - Төслүүдийн үзэл баримтлалаас харахад ИНБ, ТББ-ын өөрийн удирдлагын зарчим, орон зай руу хэт халдсан олон зохицуулалт байна. Тухайлбал одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ТББ-ын	Тухайлбал, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 8 дугаар зүйлд холбоогоор төрийн зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан болно. Түүнчлэн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангаж холбоог гишүүнчлэлтэй, бүртгэлтэйгээр үйл ажиллагааг явуулах эрхийг нээлттэйгээр зохицуулж, бүртгэлгүйгээр Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний дагуу явуулж болохоор нээлттэй зохицуулсан болно. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хориглох үйл ажиллагааг зааж өгсөн бөгөөд эдгээр үйл ажиллагааны зарим нь татан буугдах үндэслэл болно. Тухайлбал, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т холбоог 3 үндэслэлээр буюу улс төрийн намын байгууллагын үйл ажиллагааг явуулсан, шашин номлосон, шашны байгууллагын үйл ажиллагааг явуулсан, дээрх үйл ажиллагааг санхүүжүүлсэн, үндсэн зорилгоо өөрчилж ашиг хуваарилсан, иргэн аж ахуйн нэгжийн өмнөөс хөрөнгийн баталгаа гаргасан, ялгаварлан гадуурхалт явуулсан бол татан буугдахаар заасан. Харин Нээлттэй нийгэм форум, Ардчиллын боловсрол төв зэрэг байгууллагын саналд дурдсан шиг аливаа хориглосон үйл ажиллагааг бүхэлд нь явуулсан, эсхүл санхүүгийн тайланг 8 улирал дараалан гаргаагүй бол татан буугдах зохицуулалт хуулийн төсөлд байхгүй болно. Түүнчлэн
--	-------------------	---	--

	тухай хуулийн 4-р зүйлд ТББ-ыг “...үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага” гэж тодорхойлсон. Ийнхүү тодорхойлогдон хэрэгжиж байгаа “төрөөс хараат бус байх”, “өөрийгөө удирдах” гол 2 зарчим дээрх хуулиудын үзэл баримтлалд орхигдсон. - Нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй байгууллагуудыг заавал гишүүнчлэлтэй байгууллага буюу “холбоо”-ны зохион байгуулалтад орохыг тулгах, нөгөөтэйгүүр гишүүнчлэлтэй байгууллагын хувьд зөвхөн гишүүддээ үйлчилдэг ТББ болон гишүүдтэй хэдий ч нийгэмд үйлчилдэг ТББ-ыг нарийвчлан тодорхойлж зохицуулаагүй. Төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд оролцох эрхийг баталгаажуулах - Хуулийн төсөлд ТББ-ын үйл ажиллагааг төр, засгийн зүгээс дэмжлэг үзүүлэхээс илүүтэй хянах зохицуулалт давамгайлсан байна. - Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, хяналт хэрэгжүүлж, шаардлага гаргах чиглэлээр холбооны үйл ажиллагааг дэмжих, оролцооны албан ёсны механизм бий болгох бодитой шийдэл, зохицуулалт эдгээр хуулийн төслүүдэд байхгүй байна. Тэр ч байтугай төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалахтай холбоотой эрхийг баталгаажуулсан зохицуулалт ч тусаагүй байна. - Иргэний нийгмийн оролцоог тусгасан зохицуулалтууд, тэр дундаа нийтийн сонсголтой холбоотой журмуудад тухайлан иргэний нийгмийн оролцоог заасан зохицуулалтууд орж эхэлсэн. Иймд ИНБ-ын төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх зэрэг процесст оролцуулахтай холбоотой суурь зарчмыг тусгаж өгөх, УИХ-аас хариуцан нэр дэвшүүлж, сонгон шалгаруулж томилох үйл явцад албан ёсоор оролцохыг хуулиар баталгаажуулах нь зүйтэй. Иргэний нийгмийн төлөвшлийг дэмжих	эвлэлдэн нэгдэх эрхээс гадна ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагаа төрөөс хараат бус байх, өөрийгөө удирдах зарчмыг голлон үзэл баримтлал болон хуулийн төсөлд тусгасан болно. Тухайлбал, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д холбоо нь үйл ажиллагаагаа төрөөс хараат бусаар, өөрийгөө удирдан хууль тогтоомжийн хүрээнд явуулахаар заасан бөгөөд холбооны дотоод бүтэц, бүрэлдэхүүний ерөнхий журмыг уг хуулийн төсөлд тусгаж, нарийвчилсан зохицуулалтыг холбоо өөрийн дүрмээрээ зохицуулахаар заасан болно. - Төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд оролцох эрхийг баталгаажуулах: Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлд төрийн бодлого шийдвэрийн төсөл боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд оролцох, мэдээ мэдээллийг нээлттэйгээр олж авах, нийтийн ашиг сонирхлын хүрээнд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг зааж өгсөн болно. -Иргэний нийгмийн төлөвшлийг дэмжих: Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд иргэд үзэл бодлоо, чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, нийтийн эрх ашгийн хамгаалах чиглэлд зохион байгуулалтад орж, бүртгүүлэх нь
--	---	--

	- Иргэний нийгмийн төлөвшил нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх, аливаа нийтийн болон өөрийн хамаарах бүлгийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр аливаа шахалт хавчлагагүйгээр зохион байгуулалтад орж хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх үйл явцаас эхлэх бөгөөд энэхүү үзэл баримтлалыг тусгаж хуулийн зохицуулалтыг нийцүүлэх нь зүйтэй. - Иргэний нийгэм төлөвшихөд аливаа үнэт зүйл, нийтлэг ашиг сонирхлоос гадуур аливаа хууль бус зорилго зорилтын хүрээнд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байдлыг тэнцвэртэйгээр таслан зогсоох зохицуулалтыг эрэлхийлэх бөгөөд энэхүү эрсдэлээс үүдэн иргэдийн эвлэлдэн нэгдэх, иргэний нийгмийн орон зайг хумих, хянах зохицуулалт байж болохгүй юм. - Иргэний нийгмийн зөвлөлийн зохицуулалтаас харахад төрд дэмжлэг болж хамтарсан, эсвэл төр, засгийн газрын олон нийтэд зориулсан бодлого, үйл ажиллагаанд хамрагдаж чадаагүй хүмүүсийн эрх ашгийг хамгаалж, тэдэнд үйлчилсэн байгууллагууд л дэмжлэгт илүүтэй хамрагдах боломжтой, харин төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг хөндлөнгөөс хянах, бодлогод нөлөөлөх чиглэлээр ажилладаг байгууллагууд дэмжлэгийн гадна үлдэх эрсдэл харагдаж байна. - Зөвхөн Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сангаас санхүүжилт авсан эсхүл авах бол Зөвлөлд тайлан гаргахаар байгаа нь нийт ТББ-ын хариуцлага, тайлагнахыг сайжруулахад ямар хувь нэмэр оруулах нь тодорхойгүй. - ХЗДХЯ-ны дэргэд байгуулагдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар оноогоор үнэлэн шалгаруулж, өндөр оноо авсныг нь Ерөнхий сайд батламжилна гэжээ. Гэтэл хэн, ямар шалгуураар хэрхэн оноо өгөх, зөвлөлийн гишүүнд тавих шаардлага зэрэг нь тодорхойгүй байна.	нээлттэйгээр зохицуулагдсан болно. Харин улсын бүртгэлд бүртгүүлж, хуулийн этгээдийн эрх үүргийг хэрэгжүүлэхийн хүрээнд бусад хуулийн этгээдийн нэгэн адил тодорхой үүргийг хүлээхээр хуульд заасан болно. Тухайлбал, үйл ажиллагааны, санхүүгийн, татварын тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх, хуулийн этгээдээ төлөөлөх эрх бүхий этгээдээ тодорхойлох, хууль бус үйл ажиллагааг явуулахыг хориглох, зарим нийтийн эрх ашигт нийцэхгүй үйл ажиллагааг явуулахыг хязгаарлах, тусгай зөвшөөрөлтэй явуулах үйл ажиллагааг тухайн зөвшөөрлийг аваагүй тохиолдолд явуулахыг хориглох зэрэг хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг бусад хууль тогтоомжийн адил дээрх хуулийн төсөлд тусгасан. Хуульд заасан хууль бус үйл ажиллагааг ашгийн төлөө бус хуулийн этгээд буюу холбоо, санд хориглосон нь иргэний нийгмийн орон зайг хумих, хянах зохицуулалт болохгүй юм. Харин иргэний нийгмийн байгууллагууд дундаас жинхэн зарчим зорилгодоо нийцсэн байгууллагуудыг ялгаран гарч үйл ажиллагаагаа үнэлүүлэх боломжийг олгож байгаа юм. Иргэний нийгмийн байгууллагуудын орон зайг хумих, хязгаарлаж байна гэдэг үүднээс тэдгээр нь хуулиар хориглосон, хязгаарласан үйл ажиллагааг явуулах зүйд нийцэхгүй.
--	---	--

	- Зөвлөл нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд хяналт тавина гэжээ. Гэтэл энэ чиглэлийн нарийвчилсан хяналтыг банк, санхүү, тагнуулын байгууллага харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг хянах, мэдээлэх хүрээнд тогтмол хамтран хэрэгжүүлдэг. ТББ-ууд нь хуулийн этгээдийн хувьд Улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлэх ба мэдээллийн үнэн зөв байдалд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар хяналт тавьдаг. Иймд Зөвлөлөөс хэрэгжүүлэх хяналт нь дээрхээс ямар ялгаатай, мөн хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь ч тодорхой бус харагдаж байна. Харин ч зайлшгүй шаардлагатай бус давхардсан хяналт шалгалт бий болгож, ТББ-уудад нэмэлт ачаалал үүсгэхээр байна. - Холбооны тухай хуулийн төслүүд дэх мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэхтэй холбоотой заалтууд нь давхардсан, олон дахин давтагдсан байна. - Зөвлөл нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдийн жагсаалтыг гаргаж зарлана гэсэн байна. Гэтэл нийтэд тустай үйл ажиллагааны тайлан нь сайн дурын буюу зөвхөн Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сангаас дэмжлэг авах байгууллагууд л тайлан гаргахаар байна. Энэ нөхцөлд Зөвлөл нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын жагсаалтыг бүрэн гаргаж чадахгүй. - Зөвлөл нь нийтэд тустай үйл ажиллагааны тайланд хийсэн дүгнэлтийг холбогдох салбарын төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхээр байна. Тухайн ТББ нийгмийн харилцааны олон салбар чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллага бол төрийн захиргааны байгууллагыг хэрхэн тодорхойлох, Зөвлөлийн цахим хуудсанд нээлттэй тавигдсан тайланг ийнхүү тодорхой байгууллагад хүргүүлэх нь ямар ач холбогдолтой, ТББ-д ямар хүндрэл, эрсдэл учруулж болохыг анхаарах.	Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 38, 39 дүгээр зүйлд заасан Иргэний нийгмийг дэмжих зөвлөл нь иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшлийг хангах, дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, төрийн бодлого, шийдвэр боловсруулахад зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий зөвлөл болно. Энэхүү зөвлөл нь иргэний нийгмийн нийтлэг хөгжил, чадавхыг дэмжих, сурталчлахад дэмжлэг үзүүлэх данстай байхаар хуулийн төсөлд тусгасан. Дээрх зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар сонгох бөгөөд сонгон шалгаруулалт явуулах нарийвчилсан журмыг хуулийн төслийн 38.8-д Засгийн газар батлахаар заасан болно. Иргэний нийгмийг дэмжих зөвлөлд сайн дурын үндсэн дээр үйл ажиллагааны тайлангаа хүргүүлснээр холбоо нь үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах, мэдээллийн санд орох, иргэний нийгмийг дэмжих сангаас санхүүжилт авах, татварын байгууллагад татвараас хөнгөлөгдөх, чөлөөлүүлэхэд зориулсан дүгнэлт гаргуулах зэрэг сайн талтай болно. Түүнчлэн зөвлөлд тайлангаас гадна өөрийн холбоо, сангийн мэдээллээ өгч, сурталчлуулах, мэдээллийн санд оруулах арга хэмжээг авч болно. Төрийн чиг үүргийг санхүүжилтийн үндсэн дээр хэрэгжүүлж байгаа тохиолдолд заавал үйл ажиллагаа нь ил тод нээлттэй байхаас
--	--	--

	- Иргэний нийгмийг дэмжих зөвлөлд ТББ-уудын үйл ажиллагаа, санхүүжилтийг хянах, үнэлэх, дүгнэх зэргээр дотоод асуудалд нь хэт оролцох өргөн эрх мэдэл олгосон байна. - Улс төрийн нам, улс төрийн намын байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэхийг хориглох зэрэг ялгаж салгахад хэцүү, үзэмжээр тодорхойлогдох боломжтой зохицуулалтууд тусгагдсан. - Мөн төрийн бус байгууллагын олон янз байдлыг харгалзаагүй, Холбооны тухай хуульд удирдлага зохион байгуулалтыг хэт нарийвчлан тусгасан байна. Тухайлбал, сайн дураар эвлэлдэн нэгдэж байгаа ТББ-ууд нь өөрсдийн хүсэл сонирхол дээр үндэслэн ажилладаг бөгөөд тэр бүр Ажлын алба, Гүйцэтгэх захирал орон тооны ажилтнуудтай байх боломжгүй, шаардлагагүй ч байдаг. Холбооны дотоод хяналтын хороог УЗ-өөс батлах нь өөрөө бүрэн хяналт болж чадахгүй зэрэг зохион байгуулалтыг оновчтой зохицуулаагүй байна. Санхүүжилт: - ТББ-ын санхүүгийн хараат бус байдал нь түүний олон эх үүсвэрт санхүүжилт бөгөөд энэ нь тухайн байгууллагыг санхүүжүүлэгчээс хараат байх эрсдэлээс сэргийлж өгдөг. Нийтэд тустай үйл ажиллагааны санхүүжилтийн чөлөөтэй, олон талт эх үүсвэрийг дэмжих байдлаар иргэний нийгмийн орон зай, хараат бус байдлыг дэмжих байтал эсрэгээсээ төвлөрсөн байдлаар ЗГ-ын шууд хяналтад санхүүжилтийг төвлөрүүлж байгаа нь төрд хяналт тавьж ажилладаг байгууллагуудад сөрөг үр дагавартай үзэл баримтлал юм. - Хуулийн төсөл нь бүхэлдээ нийтэд тустай үйл ажиллагааг төрөөс дэмжих зорилго агуулаагүй бөгөөд энэ талаар тодорхой зохицуулалт ч тусгагдаагүй байна.	гадна чиг үүргээ шилжүүлсэн төрийн байгууллагад үйл ажиллагааны тайлангаа хүргүүлж, мэдээлж байх хэрэгтэй. Үүнийг хуулийн төсөлд зохицуулж, үүрэгжүүлж өгсөн. Энэ зүй ёсны хэрэг болно. Түүнчлэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа болон нийтэд тустай үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд тайлангаа иргэний нийгмийг дэмжих зөвлөлд хүргүүлэх үүрэгтэй бөгөөд зөвлөл тухайн тайланд хяналт шинжилгээг хийж, дүгнэлт гаргахаар заасан, уг дүгнэлт нь цаашлаад холбоог татвараас чөлөөлөх үндэслэл болж болно. Харин төрийн чиг үүргийг хэрэгжүүлээгүй, нийтэд тустай үйл ажиллагааг гүйцэтгээгүй холбооны тайланд хяналт, шинжилгээг хийхгүй байх талаар Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 36.1-д заасан болно. - Санхүүжилт: Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжилтийн эх үүсвэр нь Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлд зааснаар нийт 8 эх үүсвэрээс санхүүжүүлэх бөгөөд бусад хуулиар хориглоогүй санхүүжилт авахыг мөн зөвшөөрсөн. Харин төрөөс холбооны үйл ажиллагааг санхүүжүүлж болох бөгөөд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх, нийтэд тустай үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэлбэрээр санхүүжилтийг олохоор тусгасан болно. Түүнчлэн хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны орлого, нийтэд тустай үйл
--	---	--

	- Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сан байгуулахаар заасан боловч ийнхүү сан байгуулснаар төрийн бус байгууллагуудад тулгардаг санхүүжилттэй холбоотой өнөөгийн хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх давуу тал харагдахгүй байна. Санхүүжилтийн дэмжлэг болох татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт зэрэг тодорхой дэмжлэг байхгүй байна. Учир нь Холбооны тухай хуулийн төсөлд ч НТҮА-нд төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр, арга зам тодорхой тусаагүй байна. - Донор хандивлагч байгууллага, иргэдийн санхүүгийн дэмжлэг, хандив тусламжийг зөвхөн нэг санд төвлөрүүлэх нь төрийн бус байгууллагын санхүүжилтийн одоогийн олон талт эх үүсвэрийг хязгаарлахаар байна. - Санд хандивласан хөрөнгийг тодорхой хязгаартайгаар орлогын татвараас чөлөөлнө гэх боловч татварын хууль тогтоомжид ямар өөрчлөлт оруулах нь тодорхойгүй байна. -Мөн НТҮА-нд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх гэсэн боловч зөвхөн уг үйл ажиллагааг тогтмол буюу 2 жилээс дээш хугацаанд эрхэлж, Иргэний нийгмийн хөгжлийн дэмжих зөвлөлд (цаашид зөвлөл гэх) тайлангаа хүргүүлж, дүгнэлт гаргуулсан байгууллага л орлогын албан татвараас чөлөөлөгдөхөөр байна. Гэтэл одоогийн зохицуулалтаар ТББ-ууд нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хувьд угаасаа орлогын татвараас чөлөөлөгддөг бөгөөд аж ахуйн үйл ажиллагааны орлого нь ч татвараас чөлөөлөгддөг. Иймд хуулийн төсөл нь ТББ-уудад нэмэлт давуу тал бий болгохгүй бөгөөд харин ч эсрэгээрээ татвараас чөлөөлөгдөхийн тул нэмж дүгнэлт гаргуулах зайлшгүй бус, нэмэлт шаардлага үүсгэхээр байна. - Үзэл баримтлалд төрийн чиг үүргийг давуу эрхтэйгээр гэрээгээр гүйцэтгэх явдал нь ТББ-ын санхүүжилтийн дөнгөж 2 хувийг эзэлж байгааг нэмэгдүүлэх талаар дурдсан ч үүнд чиглэсэн тодорхой зохицуулалт хуулийн төсөлд тусгагдаагүй байна.	ажиллагааны орлого, иргэний нийгмийг дэмжих сангийн мөнгө зэрэг холбооны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах зохицуулалт шинээр орсон болно. -Хуулийн төсөл боловсруулахтай холбоотой санал: Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/195 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг нь нийт 17 гишүүнтэйгээс 7 гишүүн нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөлөл болно. Харин бусад 10 гишүүн нь төрийн байгууллага, судлаачдын төлөөлөл болно. Харин дээрх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд албан ёсоор нэр ороогүй ч төрийн бус байгууллага, нэр бүх судлаач, хүний эрхийн шинжээч нь хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагаанд албан бичгээр болон цахимаар санал өгөх, хэлэлцүүлэг зохион байгуулах, хэлэлцүүлэгт оролцох зэрэг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан арга хэлбэрээр оролцох бүрэн боломжтой болно. Саналыг тусгаагүй.
--	--	---

		- Үзэл баримтлалд НТҮА эрхэлдэг бол төрийн хөрөнгийг давуу эрхтэйгээр ашиглуулах зохицуулалт бий болгоно гэсэн боловч хуулийн төсөлд энэ нь тодорхой тусгаагүй байна. - Төрөөс дэмжлэг үзүүлэх НТҮА-ний төрлийг нэр дурдан жагсаалтаар тодорхойлсон нь хэр оновчтой шийдэл болохыг анхаарах шаардлагатай байна. Учир нь тасралтгүй хувьсан өөрчлөгдөх нийгмийн харилцааны хөгжлөөс шалтгаалан шинээр бий болсон чиглэлийг хэрхэн харгалзах нь тодорхойгүй байна. Тэрчлэн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах гэх мэт зайлшгүй дэмжих шаардлагатай чиглэлүүдийг ч орхигдуулсан байна. - Төрөөс тэргүүн ээлжид дэмжлэг үзүүлэх НТҮА-ны чиглэлийг Засгийн газраас 2 жил тутам дангаараа тодорхойлохоор байгааг эргэн харж, төрийн бус байгууллагуудын санал, нийгмийн харилцааны шаардлагыг харгалзан үзэх шаардлагатай. - Төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх үйл явцад давуу эрх бий болгож байгаа нь халаасны гэгдэх ТББ-уудыг төрүүлэх, эрх барьж байгаа намд үйлчилсэн ТББ илүү хамрагдах эрсдэлийг бий болгохоор байна. - Төрөөс нийтэд тустай үйл ажиллагаа эрхлэгч ашгийн төлөө бус хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхдээ төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг санхүүжилтийн хамт давуу эрхтэйгээр гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлэхээр заажээ. Энэ нь гэрээлэн гүйцэтгэх болон сонгон шалгаруулах үйл явц нээлттэй, ил тод байх зарчмыг алдагдуулж байна. - Одоогийн ТББ-уудын санхүүжилтийн гол эх үүсвэр болсон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийг холбоо болон сангийн санхүүжилтийн эх үүсвэр гэж тооцоогүй байна.	
--	--	---	--

		- Сангийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нийт үйл ажиллагааны 20 хувиар хязгаарласан нь хэр оновчтой эсэхийг анхаарах. Учир нь 20 хувь гэдгийг ямар үндэслэл, тооцоонд тулгуурлан гаргасан нь тодорхойгүй байна. - Тэрчлэн холбоо хандив авбал олон нийтээс хөрөнгө төвлөрүүлсэнд тооцох уу, хувийн сан нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхийг хориглосон нь ТББ-уудад хэрхэн нөлөөлөх, төсөл хөтөлбөрөөр санхүүжсэнийг хандив дэмжлэг авсан гэж үзэх үү, төслөөр санхүүждэг бол хувийн эсхүл нийтийн сангийн алинд тооцогдох гэх мэт тодруулах шаардлагатай эргэлзээтэй асуудлууд хуулийн төслүүдэд байна. - Тус хуульд төр иргэний нийгмийн харилцааг зарим талаар зохицуулсан нь ашгийн төлөө байгууллагаас НТҮА-г дэмжихтэй холбоотой зохицуулалтыг тусгаагүйгээс санхүүжилт болон хүний нөөцийн хувьд дэмжлэг авах боломжийг хязгаарлахаар байна. - Иргэний нийгмийн санхүүжилтийн шинэлэг хувилбарууд болох нийгмийн тустай бизнесийн үйл ажиллагаа (social enterprise), нийгмийн өөрчлөлтийн хөрөнгө оруулалт (impact investment), олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх (crowd-funding) зэрэг ойлголт, санхүүжилтийн хэлбэрүүдийн талаар дурдаагүй нь иргэний нийгмийг санхүүжилтийн хувьд солонгоруулж, төлөвшүүлэх хэтийн төлөвийг үл ойшоосон хэрэг болох юм. - Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд ТББ-ууд өртөхөөс сэргийлэх төрийн үүрэг хариуцлага хангалтгүй тусгагджээ. Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах, мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглож, ийм хувь хүн, байгууллагын талаарх мэдээллийг цагдаагийн болон тагнуулын байгууллага хамтран гаргаж нээлттэй мэдээлэхээр заасан. Гэвч	
--	--	---	--

		хэдий хугацаанд энэ мэдээлэл нь шинэчлэгдэх, ямар сувгаар мэдээлэгдэх зэрэг нь тодорхойгүй байна. Хууль боловсруулахтай холбоотой санал: - Төрийн бус байгууллагын хуулийг шинэчлэхтэй холбоотой бодлогын хэлэлцүүлэг явагдаж эхлээд багагүй хугацаа өнгөрч байгаа хэдий ч 2018 оноос бодлого боловсруулах үйл явц эрчимжиж эхлээд байна. Энэ удаагийн төсөл нь өмнө өргөн баригдаад буцаагдсан хуулийн төслийн үзэл санаа, зохицуулалт 3 тусдаа хуульд хувааж оруулснаас өөрөөр үзэл баримтлалын хувьд ахиц гарсан гэж үзэхгүй байна. Тиймээс өмнөх төсөлд өгч байсан зарчмын байр суурь, санал шүүмж хэвээр байгаа болохыг анхааралдаа авна уу. Иргэний нийгмийн салбарын гол хууль тогтоомжийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөлөл тун хангалтгүй байна гэж үзэж байгаа тул бидний зүгээс нэмж гурван хүний нэрийг хүргүүлсний дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өргөтгөх саналтай байна. Төрийн бус байгууллагууд нэгдэн хэд хэдэн удаагийн зөвшилцөл, хэлэлцүүлгийн үр дүнд 2020 онд “Монгол улсын төр, иргэний нийгмийн түншлэлийн Үзэл баримтлал”, “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал” гэсэн бодлогын баримт бичгийг боловсруулан хэлэлцүүлэх ажлыг эхлүүлээд байна. Энэхүү баримт бичигт дурдагдсан иргэний нийгмийн тодорхойлолт, үнэт зүйлс, зарчим, төрийн бодлогын хүрээ, дэмжлэг үзүүлэх тогтолцоо зэргийг хуулийн үзэл баримтлалд тусгах шаардлагатай. Холбогдох баримт бичгийн төслийг энэхүү саналд хавсаргав. Түүнчлэн Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэй “Иргэний орон зайн өнөөгийн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчныг бий болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох” судалгаа хийж буй бөгөөд энэхүү судалгааны үр дүн, санал зөвлөмжийг хууль боловсруулах шатанд ашиглах нь зүйтэй тул тайланг эцэслэмэгц ажлын хэсэгт танилцуулах болно.	
--	--	--	--